

**ДОРНОД АЙМГИЙН БОЛОВСРОЛЫН САЛБАРЫН 2024-2025 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛИЙН
ЗОРИЛГО, ЗОРИЛТЫН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН**

2024.05.26

№	Зорилт	Хүрсэн түвшин биелэлт/
1	Зорилт 1 Сургуулийн өмнөх болон бага боловсролын шинэлэн боловсруулсан сургалтын хөтөлбөр, сурах бичгийн тохирц, нийцлийг түшиц цэцэрлэг, сургуульд шалган туршиж, 2025-2026 оны хичээлийн жилээс үндэсний хэмжээнд хэрэгжүүлэх бэлтгэл хангах;	Сургуулийн өмнөх боловсрол: Зорилтын хүрээнд 2 арга хэмжээ, 3 чиглэлээр үйл ажиллагаа төлөвлөн 100 хувь хэрэгжүүллээ. Арга хэмжээ 1: Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 176 дугаар тогтоолоор батлагдсан “Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлал” танилцуулах сургалтыг орон нутгийн түвшинд 2 удаа онлайнаар зохион байгуулж удирдлага, багш 547, үндсэн сургалтад 35 удирдлага, багш хамрагдаж, хөтөлбөрийн үзэл баримтлал, сургуулийн өмнөх боловсролын шинэ хөтөлбөрийн талаарх мэдлэг, ойлголтыг цэцэрлэгийн 128 багш, ажилтанд түгээн дэлгэрүүлсэн. 4 удаагийн сургалтаар 710 багш, удирдах ажилтныг хамруулж, нэгдсэн ойлголтод хүрсэн. Арга хэмжээ 2: Боловсролын ерөнхий газраас зохион байгуулсан цэцэрлэгийн менежментийн зөвлөн туслах ажлаар цэцэрлэгийн эрхлэгч, арга зүйч 60 хүнд сургалтын шинэ хөтөлбөрийн арга зүй болох “Зохиолд суурилсан арга зүй”, “Төсөлд суурилсан арга зүй”, “Сонирхон судлахад суурилсан арга зүй”-г түгээн дэлгэрүүлж нийт 198 багш, багшийн туслахыг хамруулсан. Мнемотехникийн аргыг 3, AR технологийг 4, зохиолд суурилсан арга зүйг 10, шимт боловсролын арга зүйг 5 цэцэрлэг хэрэгжүүлсэн. Цагаан-Овоо сумын хүүхдийн цэцэрлэг “Үлгэрт суурилсан арга зүйг туршиж, бүс, аймгийн хэмжээнд 2 удаа цахимаар, үзүүлэх ажлыг танхимаар 1 түгээн дэлгэрүүлсэн. Үр дүн: Сургалтын шинэ хөтөлбөрийн 3 арга зүйд удирдлага, багш нар суралцаж, мэдлэг, ойлголтоо бататгасан. Цэцэрлэгийн 71 хувь нь шинэлэг 5-6 арга зүйг туршин хэрэгжүүлсэн. Ерөнхий боловсрол: Зорилтын хүрээнд 2 арга хэмжээ, 5 чиглэлээр үйл ажиллагаа төлөвлөж, 100 хувь хэрэгжүүллээ. Арга хэмжээ 1: 2025-2026 оны хичээлийн жилийн бэлтгэл ажлын хүрээнд бага боловсролын шинэчлэн боловсруулсан сургалтын хөтөлбөр, сурах бичгийн тохирц, нийцлийг шалган туршиж байгаа шинэчлэлийн талаар сургалт зохион байгуулан 1-2 дугаар ангийн сурах бичиг, дасгал ажлын дэвтрийг танилцуулж, нэгж байгууллага, багш хэрхэн хэрэгжүүлэх талаар хэлэлцүүлэг зохион байгууллаа. Бэлтгэл ажлыг хангах зорилго бүхий хэлэлцүүлэгт нийт багш нарын 82 хувь нь хамрагдав. Хэлэлцүүлгээр сургалтын хөтөлбөрийн онол, арга зүй, судлагдахууны агуулга, тэдгээрийн бүтэц, хэрэгжүүлэх болон тэгш хамруулах зарчим, эзэмшүүлэх арга зүй, үнэлгээний шалгуур зэргийг хэлэлцүүлсэн. Үр дүн: ЕБС-ийн бага ангийн туршилтын сургалтын төлөвлөгөөнд тусгасан 9 судлагдахуунаас 3-4 судлагдахуун техник технологийн хэрэгцээнд суурилсан тул бага ангийн суралцагчдын “Цахим анги” 5-ыг байгуулан, хүүхэд бүрт хүртээмжтэй таблетыг нэмэгдүүлж, 635 таблет, 50 чромбүүктэй болсон. Арга хэмжээ 2: Боловсрол судлалын доктор Н.Оюунцэцэгийн “21 дүгээр зууны боловсрол–Насан туршийн суралцахуй” I ботийн агуулгын хүрээнд суралцахуйн орчин үеийн арга зүй, загвар, хэрэглээг ерөнхий боловсролын 5 сургууль туршин хэрэгжүүлсэн. Энэ үйл ажиллагаанд бага, дунд, ахлах ангийн 356 багш хамрагдсан. Багш нар хичээлийг зөвхөн нэг загварын дагуу зохион байгуулах бус судлагдахуун, агуулгын онцлогт тохируулан суралцахуйн загвар, арга зүйгээ сонгон хэрэгжүүлэх мэдлэг, чадварт суралцсан. Ээлжит хичээлийн төлөвлөлтөд сурагчдад эзэмшүүлэх чадвар, хандлагыг тодорхой тусган хэрэгжүүлж, адил тэгш хөгжүүлж, үнэлдэг болсон.

Сургалт, арга зүйн хэлтсийн дарга Ж.Бумтуяа 99588832 Мейл хаяг:
Bumtuya@gmail.com

		Үр дүн: Боловсролын шинэчлэл, алсын хараатай уялдуулан сургалтын хөтөлбөрт сайжруулалт хийж, 21 дүгээр зууны иргэдэд эзэмшүүлэх суурь чадваруудыг хөгжүүлэхэд чиглэсэн ээлжит хичээлийн төлөвлөлтийг боловсруулж эхэлсэн.
2	Зорилт 2: Суралцагчийн нас, сэтгэхүйн онцлогт нийцүүлэн зураг, дүрс, тэмдэгт, мэдээллийн утгыг ойлгох, бичвэр эхийг ойлгож унших, илэрхийлэх, тайлбарлах, чадварыг өдөр тутам, хичээл, сургалтын үйл ажиллагаанд үр дүнтэй бүтээлчээр хэрэгжүүлэх;	Сургуулийн өмнөх боловсрол: Зорилтын хүрээнд 2 арга хэмжээ 5 үйл ажиллагааг төлөвлөн 100 хувь хэрэгжүүллээ. Арга хэмжээ 1 Хэл ярианы судлагдахуунд суурилсан мэргэжлийн багш нарын бүлгээс тулгамдаад байгаа чадварын түвшинг тогтоох судалгаанд 27 цэцэрлэг 84.3 хувьтай хамрагдсан ба бүтэн өгүүлбэрээр ярих 41.5, шуугисан, сийгсэн авиаг буруу болон сольж дуудах 49.1, орчиндоо байгаа тэмдэг, тэмдэглэгээг мэдэх утгыг тайлбарлах 51 хувьтай үнэлэгдсэн тул доктор Ж.Мөнхнасантай хамтран “Хүүхдийн авиан буруу дуудлагыг засан сайжруулах нь”, “Авиан дуудлагыг засан сайжруулах ганцаарчилсан сургалтын хөтөлбөр” сэдэвт 2 удаагийн сургалтад 163 багшийг хамруулав. Мөн 13 цэцэрлэг амьдрах ухааны хөтөлбөртөө “Сайн муу хүнсийг ялгах”, “Болно, болохгүй” тэмдэг тэмдэглэгээг таних, 10 цэцэрлэг аюулгүйн гарц зураглал, гар угаах, зөв бие засах, цэгэн иллэг хийх дараалал, хогоо ангилан хийх зураг, дуут дохио үйл ажиллагааны хүрээнд зураг тэмдэг, тэмдэглэгээний утгыг хэлэх, чадваруудыг эзэмшүүлэх зорилгоор “Зохицуулагч бамбар”, “Бяцхан илтгэгч”, “Монгол ардын үлгэр ярих” зэрэг сургалт, үйл ажиллагааг зохион байгуулж 1500 орчим хүүхдийг хамруулсан байна. Аюулгүй амьдрах ухаан сургалтын хөтөлбөрийн хүрээнд 12 цэцэрлэг замын хөдөлгөөний тэмдэг тэмдэглэгээ, олон улсын стандарт аюулгүй байдлын тэмдэгт мэдээллийг хүүхдэд ойлгуулах видео бичлэг 8, манчи карт 200, хөтөч ном 842, зурган уншлагын карт хийж сургалтад ашиглаж хэвшсэн. Арга хэмжээ 2: 4-р бүсийн цэцэрлэгийн 36 бүлгийн 924 хүүхэд төв номын сангаар үйлчлүүлсэн байна. Хэрлэн сумын 3, 7, 14, 15, 17 дугаар цэцэрлэг “Миний гэр-номын өргөө” аян өрнүүлж ажилласан бөгөөд нийт 64 гэр бүл гэртээ хүүхдийн номын булантай болсон. Үр дүн: Бага насны хүүхдийн хэл ярианы хөгжлийн чиглэлээр аймгийн хэмжээний судалгааны сан бүрдүүлэх эхлэл тавигдсан. Хэл ярианы чиглэлээр багшлахуйд тулгамдаж байгаа асуудлыг тодорхойлж, хэрэгцээнд нь тулгуурласан сургалтыг зохион байгуулж 163 бүлгийн багшийг хамруулсан. Ерөнхий боловсролын сургууль: Зорилтын хүрээнд 2 арга хэмжээ 6 үйл ажиллагааг төлөвлөн 100 хувь хэрэгжүүллээ. Арга хэмжээ 1: Суралцагчийн уншиж ойлгох, илэрхийлэх чадварыг хөгжүүлэхэд тэдний нас сэтгэхүйн онцлогт тохируулан номын сан, мэргэжлийн хөгжлийн бүлэг, эцэг эхчүүдтэй хамтран ахлах ангийн сурагчдын хүрээнд “Ном ба амьдрал”, “Нэг ном-Нэг эсээ”, “Экстемп илтгэл”, дунд ангийн сурагчдыг хамруулан “Ном уншихын ач тус”, “Бүтээлчээр уншъя”, “Номтой зочин” үйл ажиллагаа, бага ангийн сурагчдын дунд “Сүүтэй уншлага”, “Номтой зочин”, “Өглөөний цайтай уншлага”, “Нээлттэй микрофон”, “Өдөр бүр 5 минутын уншлага”, “Миний ертөнц” гэх зэрэг үйл ажиллагаанд 25 сургуулийн 4500 гаруй сурагчид хамрагдаж, ном унших сонирхол, чадвараа нэмэгдүүлэхийн зэрэгцээ ойлгосноо зургаар, бичвэрээр, хүснэгтээр, диаграммаар илэрхийлэн тайлбарлан ярих чадвараа хөгжүүлсэн. “Цахим уншигч 2025” уралдаанд 25 сургуулийн 1-11 дүгээр ангийн 2700 гаруй суралцагч амжилттай оролцон ярих, илтгэх чадвар хөгжсөн. Арга хэмжээ 2: Ерөнхий боловсролын 3 сургуулийн дунд, ахлах ангийн 242 суралцагчдад plickers апп, genially, Kahoot програмыг 4-5-р ангид QR кодтой интерактив даалгавар 24, цахим хичээл 124-ийг шинээр хийж ашигласан. Замын хөдөлгөөний талаарх тэмдэглэгээ, дүрмийн талаарх сургалтад 9 сургуулийн 484 хүүхэд хамрагдсан. 1-3-р ангийн 137 сурагчдад зурган хэлбэрээр, 3-12-р ангийн 340 сурагчдад бичвэр хэлбэрээр мөрдүүлэн хичээл үйл ажиллагааг

		зохион байгуулснаар хичээлийн дэгийг мөрдөж хэвшсэн, хичээл үр дүнтэй болж сурлагын ахицад эерэг нөлөө үзүүлж байна. Үр дүн: Суралцагчийн нас, сэтгэхүйн онцлогт нийцүүлэн хөгжүүлэх хүрээнд номыг танхимаар болон цахимаар уншихад ерөнхий боловсролын 26 сургуулийн 8403 орчим суралцагч хамрагдаж өдөр тутам, хичээл, сургалтын үйл ажиллагаанд хэрэгжүүлэн бичвэр эхийг ойлгож унших, илэрхийлэх, тайлбарлах, зураг болон тэмдэгт мэдээллийн утгыг ойлгох чадвараа хөгжүүлж байна
3	Зорилт 3: Багшийн ажлын байран дахь мэргэжлийн хамтын ажиллагааны үр дүнг сайжруулж хичээл, сургалтын үйл ажиллагааг мэргэжлийн багш нарын бүлэг, багаар хамтран суралцагчийн ялгаатай хэрэгцээнд нийцүүлэн чанартай бэлтгэн үр дүнтэй хэрэгжүүлэх	Сургуулийн өмнөх боловсрол: Зорилтын хүрээнд 2 арга хэмжээ, 11 үйл ажиллагааг төлөвлөн 100 хувь хэрэгжүүллээ. Арга хэмжээ 1: Аймгийн судлагдахуунд суурилсан 6, цэцэрлэгийн судлагдахуун болон суралцахуйд суурилсан 77, нийт 83 мэргэжлийн багш нарын бүлгээр ажилласан. Мэргэжлийн багш нарын бүлгүүд үйл ажиллагааны төлөвлөгөө, төлөвлөлт, явц, үр дүнг тайлагнах 3 удаагийн онлайн уулзалтаар давхардсан тоогоор 2400 орчим удирдлага, багш нарыг хамруулан тулгамдаж байгаа асуудлаа хэлэлцэн, харилцан туршлага солилцсон. Арга хэмжээ 2: Сургуулийн өмнөх боловсролын 1, 3, 5 дугаар бүсээс хамтран “Залуу багш нарын манлайлал” үйл ажиллагааг зохион байгуулж, “Бага насны хүүхэд зориулсан тоглоом дасгал”, “Ялгаатай байдлаар төлөвлөлт хийх нь”, “Хүүхдийн хөгжлийн үнэлгээ” сэдвийн сургалтад 204, “Зөвлөх багшийн манлайлал” үйл ажиллагаанд 425, “Сайн сургалт, үйл ажиллагаа”-нд 42 багшийг хамруулсан. Боловсролын газар, цэцэрлэгийн удирдах ажилтнаас бүрдсэн баг 14 цэцэрлэгт зөвлөн туслах ажлыг зохион байгуулан 88 багшийн сургалт, үйл ажиллагаанд арга зүйн дэмжлэг өгч, сургалтын 45 төлөвлөлтийг засан сайжруулсан. Мөн сургалт, үйл ажиллагааг 10 асуулга бүхий ажлын хуудсаар үнэлэхэд 70-78 хувьтай буюу “Хангалттай”, үйл ажиллагааны явцад хүүхдийн ялгаатай байдлыг харгалзан дэмжлэг үзүүлсэн байдал шалгуурын 76 буюу нийт багшийн 86.3 хангалттай сайн үнэлэгдсэн байна. Дорнод аймгийн Засаг даргын 2025 оны А/77 тоот захирамжаар “Цэцэрлэгийн багш” болзолт уралдааныг зохион байгуулсан. Уралдаанд бүлгийн 32 багш, 19 багшийн туслах оролцож, өөрийн сайн туршлага, арга зүйгээ түгээн дэлгэрүүлсэн. Үр дүн: 11 чиглэлийн үйл ажиллагаанд аймгийн 32 цэцэрлэгийн давхардсан тоогоор 3210 удирдах ажилтан, багшийг хамруулж, 45 хичээлийг засан сайжруулж, багшлахуй болон суралцахуйд тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэн, ажлын байранд багшийн мэргэжил арга зүйг дэмжиж ажилласан. Ерөнхий боловсролын сургууль: Зорилтын хүрээнд 3 арга хэмжээ, 14 үйл ажиллагааг төлөвлөн 100 хувь хэрэгжүүллээ. Арга хэмжээ 1: Ерөнхий боловсролын 26 сургууль нь багшийн мэргэжлийн үр чадвар, заах арга зүйг дэмжих танхимын болон цахим сургалт 355 удаа зохион байгуулж, 2227 багш ажилтан хамрагдсан. Арга хэмжээ 2: “Зөвлөх, тэргүүлэх зэрэгтэй багшийн манлайлал” үйл ажиллагааны 374 арга хэмжээнд 739 багш ажилтан, 9837 суралцагч, 4336 эцэг эх оролцсон. Суралцагчдад тулгамдаж буй бэрхшээлийг шийдвэрлэн бие даан суралцах чадварыг дэмжих зорилгоор суралцахуйд суурилсан 144 мэргэжлийн хөгжлийн бүлгээр 591 үйл ажиллагааг зохион байгуулж 1225 багш, 17711 суралцагч, 9103 эцэг эх асран хамгаалагчийг хамруулсан. Суралцахуйд суурилсан 144 мэргэжлийн хөгжлийн бүлгээр 10 чиглэлийн үйл ажиллагаанд давхардсан тоогоор 5071 удирдах ажилтан, багшийг хамруулан явцын үнэлгээг үр дүнтэй хэрэглэх арга зүйд суралцан, суралцахуйг дэмжсэн сайн хичээлийн санг 395-аар нэмэгдүүлэн 21760 суралцагч, 9390 эцэг эх, асран хамгаалагчийн оролцоог хангаж, улсын хэмжээний олимпиад уралдаан тэмцээнд 33 багш, зүүн бүсийн хэмжээнд 15 багш, аймгийн хэмжээнд 239 багш амжилт гаргасан. Арга хэмжээ 3: Судлагдахуун хариуцсан арга зүйчид мэргэжлийн хөгжлийн бүлгийн үйл ажиллагааг чиглүүлж, арга зүйгээр ханган,

		үзүүлэх хичээл, хамтын хичээл, хөтөлбөрийн сайжруулалт, сургалт, зөвлөн туслах ажил, сайн туршлага, элсэлтийн шалгалтын бэлтгэл, хөндлөнгийн шалгалт, орон нутгийн олимпиад, тайлан хэлэлцүүлэг, бүсийн сургуулийн хамтын ажиллагааг нэмэгдүүлэх 87 удаагийн мэргэжлийн бүлгийн ажил зохион байгуулж, 26 байгууллагын давхардсан тоогоор 1357 багшийг хамруулсан. Үр дүн: Багшийн ээлжит хичээлийн бэлтгэл сайжирч, асуудал шийдвэрлэх, суралцагч төвтэй бүтээлч сургалт явуулах, судалгаат хичээл зохион байгуулж хэлэлцүүлэх, сайн хичээлийн сан бүрдүүлэх, хичээлийн хэрэглэгдэхүүний төрлийг нэмэгдүүлэх арга зүйд суралцсан ба Монгол улсын Зөвлөх зэрэгтэй багшийн тоо 20, “Тэргүүлэх” зэрэгтэй багшийн тоо 51-ээр нэмэгдсэн.
4	Зорилт 4: Багш ажилтны бүтээлч үйл ажиллагаа, мэргэжлийн бие даасан байдлыг хүндэтгэсэн харилцаа, хамтран ажиллах болон сэтгэл зүйн таатай орчин бүрдүүлж, эцэг, эх, асран хамгаалагч, олон нийтийн оролцоонд тулгуурлан сурах, сургах үйлийг дэмжсэн байгууллагын эерэг уур амьсгал, соёл төлөвшүүлэх;	Сургуулийн өмнөх боловсрол 2024-2025 оны хичээлийн жилд 2 ажил төлөвлөн 100 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжүүлэн ажилласан. Арга хэмжээ 1: Сургуулийн өмнөх боловсролын 32 цэцэрлэгт “Эртэч өглөө-хамтдаа хөгжье”, “Цэцэрлэгтээ өөрчлөлт хийцгээе”, “Эерэг харилцаа- хамтын ажиллагаа”, “Бүтээлч хамт олон” “Багш ажилтнаа сонсох өдөр” зэрэг 10 сэдвээр хэлэлцүүлэг, өглөөлөг, тэмцээнд 657 багш, ажилтан, 12 цэцэрлэг бүтээлч аян өрнүүлсэн. Үр дүн: Хүүхдийн аюулгүй байдлыг хангах орчны тохижилтод 2.310.000 төгрөгийн хөрөнгө оруулалт, 700 гаруй сургалтын хэрэглэгдэхүүн материал, тоглоом, 60 гаруй цахим хичээлийг бэлтгэсэн. Арга хэмжээ 2: Монголын хүний нөөцийн хөгжлийн ассоциацийн “Өөрчлөлтийн менежмент байгууллагын соёл” сургалтад 8 цэцэрлэгийн 67 багш, Жендерийн үндэсний хорооны “Харилцан хүндэтгэе” аяны хүрээн 35 цэцэрлэгийн багш, ажилчид эцэг эхийн төлөөлөл 650 гаруй хүнийг аянд хамруулсан. Үр дүн: 8 цэцэрлэг “Эцэг эхтэй уулзах өдөр”-өөр 142 эцэг эхийн санал хүсэлтийг сонсон 45 эцэг эхэд бага насны хүүхдийн онцлог, хүүхэдтэй хэрхэн эерэг харилцах чиглэлээр зөвлөгөө дэмжлэг өгч ажилласан. Ерөнхий боловсролын сургууль: 2024-2025 оны хичээлийн жилд 2 ажил төлөвлөн 100 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжүүлэн ажилласан. Арга хэмжээ 1: Сэтгэл зүйн боловсрол олгох тренингийн 15 сургалтад 26 сургуулийн 1675 багш ажилтан, стрессээс урьдчилан сэргийлэх, байгууллагад эерэг уур амьсгал, соёлыг төлөвшүүлэх “Ажлын байран дахь сэтгэцийн эрүүл мэндийг чухалчилъя” уриан дор ярилцлага, контент, постер хэлбэрээр 44 удаагийн мэдээллийг сургуулиуд цахим бүлгэмд байршуулсан. Арга хэмжээ 2: Анги хамт олны сэтгэл зүйн таатай орчин бүрдүүлэх, багш хамт олны байгууллагын уур амьсгалыг сайжруулах, соёлыг төлөвшүүлэх зорилгоор 16 төрлийн сургалт, нөлөөллийн үйл ажиллагааг зохион байгуулсан. 6 настай хүүхдийн сэтгэл зүйн онцлог, өсвөр насны хүүхэдтэйгээ харилцах арга барил, хүүхдийн хөгжлийн үе шат гэсэн сэдвээр 1765 эцэг эхэд, 2-5 дугаар ангийн 1629 суралцагчдад “Проектив тестийн арга” ашиглан гэр бүлийн хөрөг зурах оношилгоо хийж, сэтгэл хөдлөлөө танин мэдэх сэдвийн хүрээнд 3-8 дугаар ангийн 3251 суралцагч, ялгаатай байдлыг ойлгох сэдвээр 7-11 дүгээр ангийн 3450 суралцагч, хамт олон багш, ажилчдын харилцаа, уур амьсгалыг сайжруулах үйл ажиллагааны хүрээнд дотуур байрны багш ажилчид болон, захиргаа аж ахуйн ажилчдад менежментийн багаар өртөөчилсөн бүлгийн үйл ажиллагааг зохион байгуулж, робот карт бүтээх картын арга зүйг ашиглан бүлгийн тренинг хийсэн. 9-10 дугаар ангийн 1212 суралцагч “Мэргэжил сонголт”-д дэмжлэг үзүүлж, ажилласан. Үр дүн: “Сэтгэл зүйн боловсрол олгох самбар”-аар мэдээлэл өгч, сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх 75 постерыг сургуулийн цахим бүлгэмд

		байршуулж, сэтгэл зүйн тренингид 186 албан хаагч, ганцаарчилсан ярилцлагад 16 багш, 12 ажилтан хамрагдаж, сэтгэл зүйн онцлогийг харгалзан харилцах, ажиллахад мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлсэн. Суралцагчид сэтгэл хөдлөлөө зөвөөр илэрхийлэх, эцэг эх хүүхдийнхээ нас сэтгэхүйн онцлогт тохируулан харилцаж, ойлгох, суралцагчид бие биенээ байгаагаар нь хүлээн зөвшөөрөх, ялгаварлан гадуурхахгүй байх арга барилын талаар ойлголттой болсон.
5	Зорилт 5: Үндэсний болон орон нутгийн мэргэжил дээшлүүлэх сургалтыг багш, ажилтны мэргэжлийн онол, арга зүйн мэдлэг, чадамжийг сайжруулахад чиглүүлж, ахиц үр дүнг тооцох;	Сургуулийн өмнөх боловсрол: Зорилтын хүрээнд 2 арга хэмжээ, 5 чиглэлээр үйл ажиллагаа төлөвлөн 100 хувь хэрэгжүүллээ. Арга хэмжээ 1: Боловсролын яам, Боловсролын ерөнхий газар, Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнгээс зохион байгуулсан "Сургуулийн өмнөх боловсролын бэлтгэл бүлгийн хөтөлбөр", "СӨБ-ын эрх зүйн орчны шинэчлэл", "Сургуулийн өмнөх боловсролын сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх бэлтгэл ажил, анхаарах асуудал" зэрэг 5 удаагийн сургалтад давхардсан тоогоор 510 удирдах ажилтан, багш хамрагдаж, интерактив контентын арга зүйг өдөр тутмын сургалт үйл ажиллагаанд хэрэглээ болгох, сургалт үйл ажиллагааг ялгаатай байдлаар төлөвлөх зэрэг арга зүйд суралцсан. Арга хэмжээ 2: Хүүхдийн цэцэрлэгийн багш, удирдах ажилтны мэргэжил дээшлүүлэх үндсэн сургалтад 35 хүн хамрагдан сургалтын шинэ хөтөлбөр, сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын хөтөлбөрийн үзэл эргэцүүллийн 4 арга зүйтэй танилцаж, онлайн орчинд ажиллах ур чадвар эзэмшсэн. Отгонтэнгэр дээд сургуулийн багш доктор Х.Алтанхундагатай хамтран "Блумын таксономийг ашиглан хүүхдийн хөгжлийг дэмжих сургалт арга зүй", "Бага насны хүүхдийн харилцааг дэмжих арга зам" сургалтыг зохион байгуулж багш, багшийн туслах 260 хүн, хэл ярианы мэргэжлийн багш нарын бүлгээс хэрэгцээ, судалгаанд үндэслэн хүүхдийн сэтгэл зүйч, нейро-хэл засалч, сургуулийн өмнөх насны тусгай хэрэгцээт боловсролын багш, боловсрол судлалын доктор Ж.Мөнхнасанатай хамтран "Хүүхдийн авиан буруу дуудлагыг засан сайжруулах нь", "Авиан дуудлагыг засан сайжруулах ганцаарчилсан сургалтын хөтөлбөр" сэдэвт 2 удаагийн сургалтыг цахим болон танхимаар зохион байгуулж 163 багш нарыг хамруулсан. Үр дүн: Үндэсний болон орон нутгийн 7 удаагийн сургалтаар давхардсан тоогоор 968 удирдах ажилтан, багш, багшийн туслахыг хамруулан арга зүйн дэмжлэг үзүүлсэн. Багш нар блүм, зохиолд суурилсан зэрэг 5-6 шинэлэг арга зүйд суралцсанаас гадна эргэцүүллийн 4 аргыг үйл ажиллагаандаа туршин хэрэгжүүллээ. Ерөнхий боловсрол: Зорилтын хүрээнд 3 арга хэмжээ, 5 чиглэлээр үйл ажиллагаа төлөвлөн 100 хувь хэрэгжүүллээ. Арга хэмжээ 1: Эргэцүүлэлд суурилсан багшлахуй, сургалтын цахим хэрэглэгдэхүүн бэлтгэх мэдлэг, ур чадвар, хичээлийн судалгааны арга зүйд дэмжлэг үзүүлэх зорилготой үндсэн сургалтад ерөнхий боловсролын 21 сургуулийн 113 багш хамрагдав. Үр дүн: AI хэрэгсэл болох Gemini, Napkin AI-ийг хэрхэн ашиглах, хэрэгслийн давуу болон сул тал, Google-ийн мэдээллийн санд суурилж өргөн хүрээний сэдвээр мэдээлэл боловсруулах, олон төрлийн бүтээгдэхүүн, үйлчилгээнд AI хэрэгслийг ашиглах мэдлэг, ойлголттой болсон. Арга хэмжээ 2: БЕГ-ын даргын 2022 оны 210-р тушаалаар батлагдсан "Багшийн мэргэжлийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах ажлын удирдамж" 1, 2-р хавсралт-ын дагуу багш бүр багшийн мэргэжлийн хөгжлийн төлөвлөгөө гарган биелэлтээ тооцон ажилласан ба сургуулийн менежментийн багууд багшийн ажлын гүйцэтгэлд эхний хагас жилд үнэлгээ хийж, зөвлөмж чиглэл өгсөн. Арга хэмжээ 3: Багшийн болон байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнд суурилан сургуулийн багш, ажилтны хөгжлийн төлөвлөгөөг захиалгат сургалт, судлагдахуунд суурилсан, суралцахуйд суурилсан, ажлын байрны, цахим платформд суурилсан

		сургалт, зэрэгтэй багшийн манлайлал чиглэлээр төлөвлөн багшийг ажлын байранд хөгжүүлэх зорилготой 199 сургалтад 1318 багш, удирдах ажилтан, захиалгат 76 сургалтад 1534 багш, удирдах ажилтан, цахим платформд суурилсан 156 сургалтад 909 багш, зэрэгтэй багшийн манлайллын хүрээнд явуулсан 142 сургалтад 939 багш хамрагдан, явцын үнэлгээ ба ялгаатай суралцахуй, ангитай ажиллах арга зүй, сургуулийн менежментийг төлөвлөх, багшлахуйн урлаг, эрсдэлтэй хүүхэдтэй ажиллах, анхан шатны баримт бүрдүүлэх, ялгаатай байдлыг тооцон тэгш хамруулахад явцын үнэлгээг төлөвлөх арга зүйд суралцсан. Үр дүн: Багш нар идэвхтэй сургалтын 10-аас доошгүй арга зүйг хичээлийн онцлогт тохируулан ашигласнаар ээлжит хичээлийн төлөвлөлт сайжирч, сурлагын чанарт 5-12 хувийн ахиц гарсан.
6	Зорилт 6: Суралцагчдын хамтран суралцах, багаар ажиллах үйлийг дэмжин, ажиглалт туршилт, эрэл хайгуул хийх, өөртөө итгэлтэйгээр суралцах, бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх “Төсөлт ажил” хэрэгжүүлж үр дүнг нээлттэй тайлагнах	Зорилтын хүрээнд 2 арга хэмжээ, 37 үйл ажиллагаа төлөвлөн 100 хувь хэрэгжүүллээ. Арга хэмжээ 1: Суралцагчдын хамтран суралцах, багаар ажиллах үйлийг дэмжин сургуульд суурилсан “Сансрын долоо хоног” өдөрлөг, “Байгаль миний дуранд”, “Шийдэлч сурагч”, Ногоон зүрх” эко клуб төсөл, “Монголын уламжлалт аж ахуй, малын ашиг шимийг боловсруулах арга хэмжээ, “Бүтээлчээр сэтгэж, хамтдаа хөгжье” аян, “Татмын экосистем”, “Цэн тогоруу”, “Хүрээлэн буй орчин, хөрсний найрлага, идэш тэжээлийн хэлхээ”, Физик- Хэрлэн голын усны урсгалын хурд, Газар зүйн хичээлээр эгч дүү 3 голын тухай мэдлэг, “Биологи-ундны усны хэрэглээ” экскурс хичээл зэрэг 34 арга хэмжээнд 7273 суралцагч хамрагдсан. Арга хэмжээ 2: Суралцагчдын ажиглалт туршилт, эрэл хайгуул хийх, өөртөө итгэлтэйгээр суралцах, бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх зорилго бүхий Байгаль шинжлэл-2025” төслийг хэрэгжүүлсэн. Үүнд: 1. Гэртээ туршья аян: Тус аянд Ерөнхий боловсролын 18 сургуулийн 4,5 дугаар ангийн Хүн байгаль хичээлээр-119, 6-11 дүгээр ангийн физикийн хичээлээр 384, химийн хичээлээр 549, газарзүйн хичээлээр 189, биологийн хичээлээр 100, нийт 1341 туршилтат контентийг 1360 хүүхэд бүтээж, “Дорнод Эврика” фэйж хуудсанд байршуулж, 36707 хүн контентыг үзэж сонирхсон. Аянд оролцсон суралцагчдын тоог 2024 онтой харьцуулахад 831-ээр нэмэгдсэн байна. 2. Туршилтат олимпиад: Байгалийн ухааны 4 хичээлийн 70 багийн 140 суралцагч хамрагдаж туршилтат бодлого бодож оюун ухааны сорилоо. 3. “Дорнод эврика-2025” тайлант өдөрлөгт 4 төрлөөр 23 сургуулийн 4 судлагдахууны 55 мэргэжлийн багш, химийн хичээлийн 15, физикийн хичээлийн 18, Биологийн хичээлийн 18, газарзүйн хичээлийн 8 дугуйлангийн 590 сурагч оролцож, шинжлэн ухаан танин мэдэхүйн 92 бүтээлийг танилцуулж, түгээн дэлгэрүүлэлт хийсэн. Үр дүн: Суралцагчдын шинжлэн судлах арга барил буюу амжилт чанарын үзүүлэлт 2024 онд дундаж-4.1, 2025 онд дундаж-10.8 болж өссөн. 35 дугуйлангийн 50 бүтээл, 2025 онд 59 дугуйлангийн 92 бүтээл танилцуулсан.
7	Зорилт 7. Ялгаатай хэрэгцээтэй хүүхдийг боловсролын үйлчилгээнд тэгш хамруулж, тэдний онцлог, хэрэгцээнд суурилан хөгжлийн дэмжлэгийг чанар, үр дүнтэй үзүүлэхэд талуудын оролцоо, хамтын ажиллагааг идэвхжүүлэх	Зорилтын хүрээнд 4 ажил төлөвлөн 100 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжүүлэн ажилласан. Дорнод аймгийн цэцэрлэгийн 2-5 насны 96 хөгжлийн ялгаатай хүүхдээс 8 хүүхэд байнгын асаргаатай суралцах боломжгүй. 2025 оны эхний хагас жилд 20 цэцэрлэгт 83 хүүхэд буюу 86.4 хувь, Ерөнхий боловсролын сургуулийн 6-18 насны хөгжлийн ялгаатай 289 хүүхдээс 54 хүүхэд байнгын асаргаатай суралцах боломжгүй. 2025 оны эхний хагас жилд Ерөнхий боловсролын 23 сургуульд 6-18 насны 185 хөгжлийн ялгаатай хүүхэд буюу 78.7 хувь нь хамрагдан суралцаж байна. Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн дэмжлэгийн багт ялгаатай хэрэгцээтэй хүүхдийг боловсролд тэгш хамруулах зөвлөмж, чиглэл хүргүүлэн “Хамтдаа хөгжих-Тэгш оролцоотой ирээдүйн төлөө”, “Брайл үсэг” зэрэг багш нарыг чадваржуулах сургалт, гэр айлчлал, орчны эрсдэлийн үнэлгээ, 21 хүүхдийн эрүүл мэндийн үзлэг, оношлогоо, нөхөн сэргээх

		эмчилгээ, хөгжил, оролцоог нэмэгдүүлэх 96 сургалт, уулзалт, хэлэлцүүлэг, уралдаан тэмцээнд 144 багш, удирдах ажилтан ажилтан, 1008 эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчдийг хамруулж, ойлголтыг нэмэгдүүлэн ажиллалаа. Үр дүн: Хөгжлийн ялгаатай хүүхэдтэй 7 эцэг эх, асран хамгаалагч нартай ганцаарчилсан уулзалтыг хийж, 7 хүүхдийг сургуульд хамруулж, суралцагчдад зориулсан хүртээмжтэй орчин бүрдүүлж, 14 сургууль ариун цэврийн өрөө, 25 сургууль налуу шат, 9 дотуур байр ариун цэврийн өрөөг засан сайжруулж тохижуулсан. Цэцэрлэгт хамрагдаагүй хөгжлийн ялгаатай 17, ерөнхий боловсролын 9, нийт 26 хүүхдийг хамран сургах тойргийн цэцэрлэг, сургуульд боловсролын үйлчилгээнд тэгш хамруулж, тэдний онцлог, хэрэгцээнд суурилан хөгжлийн дэмжлэгийг чанар, үр дүнтэй үзүүлэхэд талуудын оролцоо, хамтын ажиллагааг идэвхжүүлэн 2025 оны эхний хагас жилийн байдлаар 23 сургууль, 20 цэцэрлэгийн нийт 239 багшид хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажилласны нэмэгдэл нийт 505.010.3 мянган төгрөг олгосон.
8	Зорилт 8. Цэцэрлэг, сургуулийн орчин дахь хүүхэд хамгаалал, эрүүл, аюулгүй байдал-Нэгдүгээрт" арга хэмжээг цэцэрлэг, сургууль, орон нутаг, үндэсний түвшинд зохион байгуулж үр дүнг тооцох	Зорилтын хүрээнд 4 ажил төлөвлөн 100 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжүүлэн ажилласан. “Дээрэлхэл дэлгэрэх ёсгүй”, “Хүүхэд хамгаалал-Танай, Манай гэрт”, “Нууцалъя, татгалзъя” аян өрнүүлэн хүүхэд хамгааллын шинэчилсэн хуулийг таниулах, хүүхдийн эрх, аюулгүй байдлыг хангах 15 сэдвээр 32 цэцэрлэг, 26 сургуулийн 1600 багш, ажилтан, 9775 эцэг эх, асран хамгаалагч, 10786 суралцагчдыг хамруулж, боловсрол, гэр бүл, цахим орчин дахь хүүхэд хамгааллын үйлчилгээг сайжруулах, олон нийтийн оролцоог нэмэгдүүлсэн. “Электрон тамхины хор уршиг”, “Хүүхэд хамгаалалд эцэг эхийн үүрэг оролцоо”, “Аюулгүй амьдрах ухаан”, “Амьдралд ойрхон харилцаа”, “Хүмүүжлийн эерэг арга” 5 төрлийн сургалтад 1630 багш, 416 ажилтан, 52132 суралцагч, 27478 эцэг эх, асран хамгаалагчийг хамруулж, хүүхдийн эрүүл аюулгүй байдлыг хамгаалах мэдлэг ойлголтыг нэмэгдүүллээ. Хүүхэд хамгааллын багийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, ажил үйлчилгээний чанар хүртээмж, эцэг эх, асран хамгаалагчдын үүрэг оролцоог нэмэгдүүлэх 7 төрлийн чиглэл зөвлөмжийг хүргүүлэн 32 цэцэрлэг, 26 сургуулийн 12902 эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, 833 хүүхдийн гэр айлчлал хийж боловсрол болон гэр бүлийн орчин дахь хүүхэд хамгааллын ажил үйлчилгээг хүргэсэн. Үр дүн: 26 сургууль, 18 дотуур байрын орчинд гадаад, дотоод орчны үнэлгээг улирал бүр хийж хүүхдийн сурч боловсрох, аюулгүй байдлыг хангах 87.393.000 төгрөгөөр орчны эрсдэлийг бууруулах үйл ажиллагааг зохион байгуулж 7.8 хувиар бууруулав. Эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх сургалтыг 687 багш, албан хаагч, 3451 эцэг эх, асран хамгаалагч, 6921 хүүхдэд зохион байгуулсан. “Охидод ээлтэй сургууль”, “Жендэрт суурилсан хүчрхийлэлтэй тэмцэх”, “Хүн бүр сэрэмжлүүлье “Нандин хайрцаг” зэрэг аянууд, “Цэвэр гар-Эрүүл ирээдүй”, “ХПВ-ын эсрэг дархлаажуулалтад хамрагдай” сэдэвт геел бичлэг, гар зургийн уралдааныг зохион байгуулсан. Үр дүн: Сургалтын байгууллагын орчинд электрон тамхийг хэрэглэхийг хориглох 28 сургалт, нөлөөллийн ажил, аянд 2987 эцэг эх, асран хамгаалагч, 8124 суралцагч хамрагдсан.
9	Зорилт 9. Гамшиг (уур амьсгалын өөрчлөлт, салхи, шуурга, ган зуд үер, газар хөдлөлт гэх мэт), болзошгүй аюул, эрсдлийн үед өөрийгөө болон бусдыг хамгаалах, туслах, бэлэн	Зорилтын хүрээнд 8 үйл ажиллагааг 100 хувь хэрэгжүүлсэн. Арга хэмжээ 1. Зүүн бүсийн төв аймгийн Онцгой байдлын газар, Боловсролын газар хамтран зохион байгуулсан “Аюулгүй амьдрах ухаан” сургалтын хөтөлбөр гамшиг, аюулт үзэгдлээс өөрийгөө болон бусдыг хамгаалах мэдлэг дадалд сургах төлөвлөсөн арга хэмжээнд 1-12 дугаар ангийн 11152 сурагч буюу нийт сурагчдын 55.6 хувь, багш ажилтны 62.7 хувь, эцэг эх, асран хамгаалагч нарыг хамрууллаа. “Гамшиг болон гал түймрийн үед өөрийгөө хэрхэн хамгаалах вэ?”, “Гэрийн болон

	байдлыг хангах мэдлэг, чадвар, дадал хэвшилтэй болоход суралцагчдад дэмжлэг үзүүлэх арга хэмжээг мэргэжлийн байгууллагатай хамтран улирал бүр оролцоонд суурилан үр дүнтэй зохион байгуулж хэвших;	сургуулийн орчин дахь эрсдэлийн үнэлгээ”-ний асуулгаар бага болон дунд ангийн суралцагчдаар эрсдэлийн үнэлгээ хийлгэж, эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх төлөвлөгөө боловсруулсан. “Анхны тусламжийн хайрцагт юу багтах вэ?”, “Газар хөдлөлтийн үед миний нэн түрүүнд хийх үйлдэл” гар зураг болон зурагт хуудсаар үзэсгэлэн гаргасан. Бага ангийн 200 гар зургийн бүтээл, дунд ангийн 80 орчим зурагт хуудас хийн байршуулсан үзэсгэлэнг 5200 гаруй хүнд түгээлээ. Арга хэмжээ 2: Гамшгийн зарлан дуудах дуут дохио, дадлага сургуулилалтад 26 сургууль, 32 цэцэрлэгт ажиллаж байсан албан хаагч, суралцагчид 100 хувь хамрагдаж, “Суу, нуугд, хүлээ” дүрмийг баримтлан, хамгийн ойр байрлах аюулгүй талбай руу нүүлгэн шилжүүлэлтийн дадлага сургуулилтыг хийсэн. “Өсвөрийн аврагч-2025” уралдааныг аймгийн Онцгой байдлын газар болон Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын газар, Улаан загалмайн хороотой хамтран ЕБС-ийн оролцоог нэмэгдүүлсэн, хүүхэд бүр гамшгаас хамгаалах мэдлэг, ур чадварыг эзэмшүүлэх танхим, цахим хосолсон сургалтын 25 байгууллагын “Өсвөрийн улаан загалмайн бүлгэмийн суралцагч, багш нарт 2 удаа зохион байгуулж үйл ажиллагааг дэмжсэн. “Өсвөрийн аврагч 2025” тэмцээнд ерөнхий боловсролын 8 сургуулийн 56 суралцагч хурд, хүч авхаалж самбаагаа сорин өрсөлдсөн. Үр дүн: 8 чиглэлийн ажилд 26 сургуулийн 11500 суралцагчдыг хамруулж болзошгүй аюул, эрсдэлийн үед өөрийгөө болон бусдыг хамгаалах, туслах, бэлэн байдлыг хангах мэдлэг, чадвар, дадал хэвшилтэй болоход нь дэмжлэг үзүүллээ.
10	Зорилт 10. Дунд, ахлах ангийн суралцагч ажил мэргэжлийн чиг баримжаатай болох, мэргэжлээ зөв сонгоход дэмжлэг үзүүлэхэд чиглэсэн зорилтот арга хэмжээг сургууль бүр төлөвлөн, үр дүнтэй хэрэгжүүлэх	Зорилтын хүрээнд 2 арга хэмжээ 5 үйл ажиллагааг төлөвлөн 100 хувь хэрэгжүүллээ. Арга хэмжээ 1 Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох санал асуулга болон мэлээллээр хангах хүрээнд 8, 9-р ангийн сурагчдаас ажил мэргэжлийн чиг баримжааны талаар судалгаа авч “Мэргэжлээ хэрхэн сонгох вэ” сургалтыг 25 сургууль 57 удаагийн сургалт мэдээллийг 1519 суралцагчид, ахлах ангийн хүрээнд 18 сургууль 76 удаагийн сургалтыг 1821 суралцагчид, мэргэжлээ зөв сонгоход хэрхэн дэмжлэг үзүүлэх талаар мэдээлэлд 1465 эцэг эхийг хамруулсан. Арга хэмжээ 2 Ерөнхий боловсролын 6 сургууль ахлах ангийн 460 сурагчдад “Сурагчийн мэргэжил сонголтыг тодорхойлох нөөц боломж” хичээлийг танхим болон цахимаар заасан. Ерөнхий боловсролын 3 сургууль Аймгийн НТБТ-ийн захирал Ц.Борхүүхэн “Ажил мэргэжлийн чиг баримжаа” сургалтыг 10-12 дугаар ангийн 76 суралцагч, 81 эцэг эхэд явуулсан. Хөдөө аж ахуйн газраас мэргэжил сурталчлах өдөрлөг, Хөдөлмөр халамж үйлчилгээний газраас “Z үеийн онцлог ба мэргэжил сонголт” сургалт, “Мэргэжлээ крашлая”, “Мэргэжлээ хэрхэн сонгох вэ” өдөрлөгийн хүрээнд ерөнхий боловсролын 10 сургуулийн 10-12-р ангийн 318 суралцагч, 92 эцэг эх Нийтийн аж ахуйн газар, Хөдөө аж ахуйн газар, Мэргэжил сургалт, үйлдвэрлэлийн төв, Политехник коллеж, МУИС-ийн зүүн бүсийн сургууль Цагдаагийн газар, Дорнод аймгийн Онцгой байдлын газрын үйл ажиллагаатай танилцав. Сумын төрийн болон үйлчилгээний албан байгууллагууд хамтран насан туршийн боловсролын төвийг түшиглэн 8-9 дүгээр ангийн 272 суралцагчдад “Мэргэжил сурталчлах 7 хоног” аяныг 8 сургууль зохион байгуулж хүссэн мэргэжлээ сонгож ажиллах ач холбогдлын талаарх хэлэлцүүлэг зохион байгууллаа. Үр дүн: Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйл ажиллагаанд Дорнод аймгийн 25 сургуулийн дунд ахлах ангийн 3340 суралцагч, 1465 эцэг эхэд мэргэжлийн онцлог, агуулга, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, хэрэгцээ өөрийн сонирхол, чадвартаа тохирсон мэргэжлийг хэрхэн сонгох тухай мэдлэг, мэдээллээр хангаж ажиллав.
11	Зорилт 11. Төрөлжсөн ахлах сургуулийг хөгжүүлэх	Боловсролын Сайдын 2025 оны 05 сарын 02-ны өдрийн А/188 тушаалаар батлагдсан “Төрөлжсөн ахлах сургуулийн баримтлах чиглэл”-ийг баримтлан 2025-2026 онд хичээл сургалт, үйл ажиллагааг

	загварыг боловсролын асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллага бүр олон талын оролцоотой боловсруулж, хэрэгжүүлэх бэлэн байдлыг хангах	тодорхой болгох, ахлах сургуулийн цаашид төрөлжих чиглэл, сургалтын үйл ажиллагаа, ном сурах бичиг, гарын авлага, сургалтын хэрэглэгдэхүүний хангалт, байгалийн ухаан, нийгэм хүмүүнлэгийн чиглэлээр төрөлжүүлэх бэлтгэл ханган ажиллаж байна.
12	Зорилт 12. Цэцэрлэг, сургууль бүр суралцагчдад “Өдөр бүр –Сүү” арга хэмжээг нутгийн захиргааны байгууллага, эцэг, эх асран хамгаалагчийн оролцоо, дэмжлэгтэйгээр хамтран хэрэгжүүлж, хүүхдийн өсөлт, эрүүл мэндийг дэмжих	“Өдөр бүр-Сүү” арга хэмжээг хэрэгжүүлэх чиглэлээр 4 үйл ажиллагааг төлөвлөн ажилласан. Арга хэмжээ 1: Сургуулийн өмнөх боловсрол, ерөнхий боловсролын сургуульд “Өдөр бүр-Сүү” арга хэмжээг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зөвлөмж хүргүүлэх үйл ажиллагааны хүрээнд 13 заалтаар зөвлөмж боловсруулан нэгж байгууллагуудад албан бичгээр хүргүүлэн ажилласан. Арга хэмжээ 2: Өдөр бүр-Сүү арга хэмжээг хэрэгжүүлэх зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавих ажлын хүрээнд сургуулийн өмнөх боловсролын 15 байгууллага, ерөнхий боловсролын 9 сургуульд хяналт, зөвлөмж чиглэл өгч ажилласан. Арга хэмжээ 3: “Өдөр бүр-Сүү” арга хэмжээг зохион байгуулж байгаа нэгжийн судалгааг гарган нэгтгэх хүрээнд 3 удаа судалгаа мэдээллийг нэгж байгууллагуудаас авч нэгтгэн авсан. Арга хэмжээ 4: “Өдөр бүр-Сүү” арга хэмжээг сургалтын байгууллагад хэрэгжүүлэх, дэмжлэг үзүүлж ажиллах хүрээнд хүүхдийн эрүүл мэнд, өсөлт хөгжлийг дэмжих арга хэмжээг 32 цэцэрлэгийн 30 буюу 93.7 хувь нь орон нутаг, хүүхдийн хоолны түүхий эдийн зардал болон эцэг эхийн оролцоо дэмжлэгээр нийт 192.3 сая төгрөгийг зарцуулан, 7 хоногийн 2-5 өдөрт хэрэгжүүлж нийт 6024 хүүхдийг, төрийн болон хувийн өмчийн 26 сургуулийн 20 буюу 76.9 хувь нь орон нутаг, хүүхдийн хоолны түүхий эдийн зардал болон эцэг эх, асран хамгаалагчдын оролцоо дэмжлэгээр нийт 116.9 сая төгрөгийг зарцуулан, 7 хоногийн 1-5 өдөрт хэрэгжүүлж нийт 8084 суралцагчийг хамруулан ажиллалаа. Үр дүн: Сургалтын 50 байгууллагад хэрэгжүүлэн хүүхдийн эрүүл мэндийг дэмжин ажиллаж орон нутаг, хүүхдийн хоолны түүхий эдийн зардал болон эцэг, эхийн дэмжлэгээр 14108 суралцагчийг хамруулав. 4 арга хэмжээний хэрэгжилт 96.5 хувьтай.

ТАЙЛАН НЭГТГЭСЭН: ХЭЛТСИЙН ДАРГА Ж.БУМТУЯА

Сургалт, арга зүйн хэлтсийн дарга Ж.Бумтуяа 99588832 Мейл хаяг:
Bumtuya@gmail.com